



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/48

Мандалговь

┌ Залуучуудын хөгжлийн зөвлөл ┐
байгуулах тухай

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 13 дугаар зүйл, 14 дүгээр зүйл, Засгийн газрын 2019 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан "Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр"-ийн 5.2.8 дахь заалт, Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоол, "Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм батлах тухай" Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/72 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Залуучуудын үзэл бодлыг сонсох, хүндэтгэх, хөгжил оролцоо, санал, санаачилгыг дэмжих болон тэдгээрийн эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах зорилгоор Залуучуудын хөгжлийн зөвлөлийг байгуулсугай.

2. Залуучуудын хөгжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хамт олноос авсан саналыг үндэслэн хавсралтаар баталсугай.

3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/72 дугаар тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм"-ийн хүрээнд зохион байгуулж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжлийн төвийн сургалт хариуцсан ажилтан, Залуучуудын хөгжлийн зөвлөлийн нарийн бичиг /Т.Насандэлгэр/-д даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хагас бүтэн жилээр тайлагнахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжлийн төвийн сургалт хариуцсан ажилтан, Залуучуудын хөгжлийн зөвлөлийн нарийн бичиг /Т.Насандэлгэр/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

480190095